



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ  
ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠦᠭᠢᠨ  
ᠵᠢᠰᠠᠭ ᠳᠠᠷᠦᠨ  
ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 04 сарын 06 өдөр

Дугаар A/1008

Алтай хот

Захирамжийн хавсралтад нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг, Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам"-ын 4.3.1, 4.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Аймгийн Засаг даргын 2023 оны А/41 дүгээр захирамжийн хавсралтад дор дурдсан нэмэлт оруулсугай.

№	Эрх бүхий албан тушаал	Танилцах эрхийн түвшин, зэрэглэл		
		1 дүгээр түвшин буюу "онц чухал нууц", "маш нууц", "нууц" зэрэглэл	2 дугаар түвшин буюу "маш нууц", "нууц" зэрэглэл	3 дугаар түвшин буюу "нууц" зэрэглэл
17	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн		+	
18	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн төлбөр тооцоо хариуцсан мэргэжилтэн		+	

2.Жагсаалтад орсон албан тушаалтан солигдсон тухай бүр холбогдох хууль, журамд заасны дагуу аюулгүй байдлын шалгалтад хамруулан баталгаа гаргуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын нууц хамгаалах ажилтан (Б.Золжаргал)-д үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР